
МАЭ

2026/03

"ЧОЙЖИН ЛАМЫН СҮМ МУЗЕЙН"

САН ХӨМРӨГ, ЗАХИРГААНЫ БАРИЛГА АРХИТЕКТУРЫН ЗУРАГ ТӨСЛИЙН УРАЛДААН



2026 он

01 АРХИТЕКТУРЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ УРАЛДААНЫ УРИЛГА

Монголын Архитекторуудын Эвлэл ба Чойжин ламын сүм музейн 2026 оны хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд хийгдэх, Чойжин ламын сүм музей сан хөмрөг оффисын барилгын зураг төсөл боловсруулах мэргэжилтнүүд, аж ахуй нэгж байгууллагыг уралдаанд оролцохыг урьж байна. Үүнд:

ЗОРИЛГО

Түүх, соёлын өвийн үнэ цэнийг хадгалан хамгаалах зарчимд нийцүүлэн Чойжин ламын сүм музейн үйл ажиллагааны хэрэгцээг хангах архитектур, хот байгуулалт, орон зайн төлөвлөлтийн оновчтой шийдлийг тодорхойлох, бүтээлч шинэ санааг дэмжих, хэрэгжүүлэх боломжтой шилдэг зураг төслийг сонгон шалгаруулахад оршино.

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

- Чойжин ламын сүм музейн захиргаа удирдлага
- Монголын Архитекторуудын Эвлэл

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

- Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хууль;
- Монгол Улсын Хот байгуулалтын тухай хууль;
- Монгол Улсын Барилгын тухай хууль;
- Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм;
- Олон улсын Архитекторуудын Холбоо (UIA)-ны Архитектурын уралдааны журам;
- Монголын Архитекторуудын Эвлэлийн холбогдох дүрэм, журам;
- Үнэлгээний хорооны журам
- Бусад холбогдох стандарт, норматив баримт бичиг

УРАЛДААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Уралдаан нь Чойжин ламын сүм музейн нутаг дэвсгэрт төлөвлөгдөж буй сан хөмрөгийн барилга байгууламж, орчны тохижилт, нийтийн эзэмшлийн орон зай болон тэдгээрийн түүхэн орчинтой харилцан уялдах архитектур төлөвлөлтийн шийдлийг хамарна.

УРАЛДААНД ОРОЛЦОГЧИД

- Архитектор
- Хот төлөвлөгч
- Ландшафтын архитектор
- Уран бүтээлчид
- Мэргэжлийн зураг төслийн байгууллага

УРАЛДААНД ОРОЛЦОГЧИД

- Уралдаан зарласнаас хойш 14 хоногийн хугацаанд оролцогчид уралдааны даалгавар, шаардлага болон бусад холбогдох асуудлаар тодруулга зохион байгуулагчийн албан ёсны цахим шуудангийн хаяг болох **uma.competition.mn@gmail.com** хаягаар ирүүлнэ.
- Асуулт, тодруулгыг болон шаардлагатай нэмэлт тайлбар, зохион байгуулагчид баталгаажуулсны дараа бүх бүртгүүлсэн оролцогчдод нэгэн зэрэг хүргэх буюу нийтэд нээлттэй мэдээлнэ.
- Нийтлэгдсэн асуулт, хариулт, нэмэлт тайлбар нь уралдааны баримт бичгийн салшгүй хэсэг байх бөгөөд шаардлагатай тохиолдолд уралдааны нөхцөл, шаардлагыг тодруулж, нэмэлт өөрчлөлт оруулж болно.

УРАЛДААНЫ ТӨРӨЛ

- Нэг үе шаттай
- Хоёр үе шаттай

УРАЛДААНЫ БҮТЭЭЛД АШИГЛАХ ХЭЛ

Уралдааны бүх баримт бичиг, тайлбар болон төслийн материал нь монгол хэлээр боловсруулсан байна.

НУУЦЛАЛТАЙ ШАЛГАРУУЛАЛТ (ANOMOUS SELECTION)

.

- Оролцогч бүр өөрийн бүтээлд таних тэмдэггүй, давтагдашгүй код ашиглана. Оролцогчийн нэр, хаяг, холбоо барих мэдээллийг тусгай битүүмжид хийж, зөвхөн тухайн кодоор тэмдэглэн шүүгчдэд хүргүүлнэ.
- Уралдааны материалыг хүлээн авах, бүртгэх ажиллагааг шүүгчдийн бүрэлдэхүүнээс хараат бус эрх бүхий нарийн бичиг хариуцна. Тэрээр оролцогчийг таних боломжтой аливаа мэдээллийг нууцлан хадгалж, шүүгчдийн зөвлөлд зөвхөн кодоор бүртгэсэн материалыг хүргүүлнэ.
- Шүүгчдийн шийдвэр эцэслэн батлагдсаны дараа оролцогчийн мэдээллийг нийтэд зарлана.
- Нууцлалын зарчмыг зөрчсөн, эсхүл оролцогчийг таних боломжтой мэдээлэл агуулсан материалыг шүүгчдийн зөвлөлийн шийдвэрээр уралдаанаас хасаж болно.

МАТЕРИАЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 110*160 хэмжээтэй 1–4 самбар (Оролцогчид эхний ба хоёрдугаар шатны шалгаруулалтад аль алинд самбар бэлдэж оролцоно.)

АГУУЛГА

- Самбар нь дор дурдсан үндсэн мэдээллийг агуулсан байна. Үүнд:
- Архитектурын үзэл баримтлал (концепц);
- Ерөнхий төлөвлөгөө;
- Давхрын төлөвлөлт;
- Фасадын зураг;
- Огтлолын зураг;
- 3 хэмжээст дүрслэл (3D visualization);
- Хүрээлэн буй орчин, тохижилтын шийдэл;
- Түүхэн орчинтой уялдсан төлөвлөлтийн тайлбар.
- Шаардлагатай гэж үзвэл оролцогч нэмэлт схем, диаграмм, дүрслэлээр төслөө тайлбарлаж болно.

ТАЙЛБАР БИЧГИЙН БҮРДЭЛ

Оролцогч нь төслийн үзэл баримтлал болон үндсэн шийдлүүдийг тайлбарласан 20 нүүрээс ихгүй тайлбар бичиг ирүүлнэ.

- Тайлбар бичигт дараах мэдээллийг тусгана:
- Төслийн үзэл баримтлал;
- Хот байгуулалтын шийдэл;
- Архитектурын шийдэл;
- Соёлын өвийн орчинтой уялдсан байдал;
- Тогтвортой хөгжлийн болон байгаль орчны шийдэл;
- Хэрэгжүүлэх боломжийн товч тайлбар
- Нэмэлт тооцоолол ирүүлж болно

ФАЙЛЫН ШААРДЛАГА

Оролцогч нь дараах цахим материалыг ирүүлнэ:

- Самбаруудыг PDF форматтай нэг файл болгон бэлтгэсэн байх;
- Самбар тус бүрийг JPG эсвэл PNG форматтайгаар ирүүлэх боломжтой байх;
- Нийт файлын хэмжээ 5 GB-аас ихгүй байх;
- Файлыг зохион байгуулагчаас заасан цахим хэлбэрээр (цахим шуудангаар) ирүүлнэ.
- Шаардлагатай тохиолдолд файлыг зөөврийн санах ой (USB) дээр давхар ирүүлж болно.

ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР

№	Үзүүлэлт	Хувийн жин
1	Архитектурын шийдэл	20%
2	Монголын үндэсний шийдэл үнэ цэн	20%
3	Хот өнгө төрх, харагдацын шийдэл	15%
4	Инноваци, бүтээлч байдал	15%
5	Хэрэгжих боломж	15%
6	Ногоон хөгжил, тогтвортой байдал	5%
7	Танилцуулга, материалын иж бүрдэл	10%
	Нийт оноо	100

Шүүгчдийн зөвлөл дараах 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

1. Соёлын яамны төлөөлөл
2. Соёлын өвийн үндэсний төв
3. Чойжин ламын сүм музейн төлөөлөл
4. Захиалагчийн төлөөлөл
5. Монголын Архитекторуудын Эвлэлийн төлөөлөл
6. Монголын Урчуудын эвлэл
7. Хот төлөвлөлтийн мэргэжилтэн
8. Сэргээн засварлалтын архитектор
9. Хараат бус мэргэжлийн архитектор
10. Нарийн бичиг (саналын эрхгүй)

ШҮҮГЧДИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- Шүүгчдийн зөвлөл нь уралдааны материалуудыг батлагдсан үнэлгээний шалгуурын дагуу нэргүйгээр хянан үзэж, үнэлгээ хийнэ.
- Шүүгчид шийдвэр гаргахдаа хараат бус, бие даасан байх бөгөөд үнэлгээний үйл ажиллагаанд аливаа гаднын нөлөөлөлгүйгээр оролцоно.
- Шүүгчдийн шийдвэр нь эцсийн байх бөгөөд үнэлгээний дүн, үндэслэлийг Шүүгчдийн тайланд тусгана.
- Шүүгчид уралдааны явцад олж мэдсэн мэдээлэл болон хэлэлцүүлгийн агуулгын нууцлалыг хадгалах үүрэгтэй.
- Шүүгч нь оролцогчтой шууд хамааралтай, эсхүл тухайн төслийн талаар урьдчилан мэдээлэлтэй болсон тохиолдолд өөрөө татгалзан гарч, орлох шүүгчээр солигдоно
- Шүүгч өвчин, ашиг сонирхлын зөрчил, эсхүл бусад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд зохион байгуулагч орлох шүүгчийг томилно.
- Орлох шүүгч нь үндсэн шүүгчийг албан ёсоор орлосон тохиолдолд санал өгөх эрхтэй байна.

МАТЕРИАЛЫН ШАЛГАЛТ

Зохион байгуулагчид нь шүүгчдийн үнэлгээ эхлэхээс өмнө дараах оролцоог хасаж болно:

- Материал хүлээн авах эцсийн хугацаанаас хоцорч ирүүлсэн;
- Нууцлалын зарчмыг зөрчсөн;
- Журмаар шаардсан материалыг бүрэн ирүүлээгүй;
- Уралдааны нөхцөл, шаардлагыг ноцтой зөрчсөн.

УРАЛДААНЫ ХУГАЦАА

Үйл ажиллагаа	Хугацаа
Уралдаан зарлах	2026.06.15
Бүртгэл эхлэх	2026.06.20
Асуулт хүлээн авах, хожуу бүртгэл	2026.06.30 – 2026.07.05
Эхний шатны материал хүлээн авна. эцсийн хугацаа	2026.08.05
Шалгарсан оролцогчдод мэдээлэл хүргэнэ.	2026.08.05 – 2026.08.07
Хоёр дахь шатны материал хүлээн авах	2026.08.07 – 2026.09.05
Шалгаруулалт	2026.09.07- 2026.09.11
Дүн зарлах	2026.09.15
Үзэсгэлэн гаргах	2026.09.20- 2026.09.30

Шүүгчдийн зөвлөл төслийг үнэлэхдээ дараах хүчин зүйлсийг харгалзан үзнэ. Үүнд:

- Чойжин ламын сүм музейн түүхэн болон соёлын үнэ цэнийг хадгалсан байдал;
- Түүхэн орчин, хотын дүр төрхтэй зохицсон архитектур төлөвлөлтийн шийдэл;
- Газрын нөхцөл, орчны онцлогтой уялдсан байдал;
- Үйл ажиллагааны зохион байгуулалт, ашиглалтын үр ашиг;
- Архитектурын үзэл баримтлалын чанар, орон зайн шийдэл;
- Барилга байгууламжийн гоо зүй, дүр төрх;
- Материал, бүтээцийн зохистой сонголт;
- Байгаль орчин, нийгмийн тогтвортой хөгжлийн шаардлагыг хангасан байдал;
- Төслийн цогц уялдаа холбоо, хэрэгжүүлэх боломж.

ШАГНАЛЫН САН

15,000,000
Тэргүүн байр

8,000,000
Дэд байр

5,000,000
Гутгаар байр

2,000,000
Тусгай байр

ОЮУНЫ ӨМЧ

- Уралдаанд ирүүлсэн бүх бүтээлийн зохиогчийн эрх нь тухайн бүтээлийг боловсруулсан оролцогчид хадгалагдана.
- Оролцогч нь ирүүлсэн бүтээл нь гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрхийг зөрчөөгүй бөгөөд бүтээлийн зохиогч мөн болохыг баталгаажуулна.

ШАЛГАРСАН БҮТЭЭЛИЙГ АШИГЛАХ ЭРХ

- Тэргүүн байрт шалгарсан бүтээлийг цаашид хөгжүүлэх, зураг төслийн дараагийн шатанд ашиглах асуудлыг захиалагч болон зохиогчийн хооронд байгуулсан гэрээний үндсэн дээр шийдвэрлэнэ.
- Захиалагч нь зохиогчийн зөвшөөрөлгүйгээр уралдаанд ирүүлсэн аливаа бүтээлийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн ашиглах, өөрчлөх, хэрэгжүүлэх эрхгүй.

ЗУРАГ ТӨСЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

- Тэргүүн байрт шалгарсан оролцогчид зураг төслийн дараагийн шатны ажилд оролцох, зураг төслийн үйлчилгээ үзүүлэх давуу эрх олгож болно.
- Зураг төслийн үйлчилгээ үзүүлэх нөхцөл, хамрах хүрээ, эрх үүргийг тусгай гэрээгээр зохицуулна.

НИЙТЛЭХ БОЛОН ҮЗЭСГЭЛЭН ГАРГАХ ЭРХ

- Зохион байгуулагч нь уралдааны үр дүнг нийтэд мэдээлэх, үзэсгэлэн гаргах, хэвлэн нийтлэх зорилгоор ирүүлсэн бүтээлүүдийг зохиогчийн нэрийг дурдан ашиглах эрхтэй.
- Оролцогч нь уралдааны үр дүн албан ёсоор зарлагдахаас өмнө төслөө олон нийтэд нийтлэхгүй байх үүрэгтэй.
- Энэхүү хязгаарлалт нь шүүгчид болон зохион байгуулагчид мөн адил хамаарна.

БУСАД ЗҮЙЛ

- Шүүгчдийн зөвлөлийн шийдвэр нь эцсийн байна.
- Уралдаанд ирүүлсэн материалуудыг буцаан олгохгүй бөгөөд зохион байгуулагч архивлан хадгална.
- Зохион байгуулагч нь уралдааны бүтээлүүдийг зохиогчийн нэрийг дурдан олон нийтэд танилцуулах, үзэсгэлэн гаргах, хэвлэн нийтлэх болон мэдээллийн хэрэгслээр сурталчлах эрхтэй.
- Уралдааны журам, зохион байгуулалт, үнэлгээтэй холбоотой гомдол, маргааныг эхний шатанд Монголын Архитекторуудын Эвлэлийн дэргэдэх холбогдох мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлж болно.
- Зохион байгуулагч нь шаардлагатай тохиолдолд журмын агуулгад нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй бөгөөд уг өөрчлөлтийг бүх бүртгүүлсэн оролцогчдод албан ёсоор мэдэгдэнэ.
- Энэхүү журам батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.
- Оюуны өмч, зохиогчийн эрхтэй холбоотой маргааныг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

06



ЗОХИОН БАЙГУУЛАГЧААС ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ МАТЕРИАЛУУД

Суурь судалгааны материал

1. Өрөө тасалгааны хэрэгцээ шаардлага, захиалагчаас;
2. Чойжин ламын сүм музейн түүхэн товчоо;
3. Соёлын өвийн хамгаалалтын зэрэглэл;
4. Холбогдох судалгаа, тайлан;
5. Асуулт, хариултын цахим хурал (шаардлагатай тохиолдолд).

Газрын мэдээлэл

1. Кадастрын зураг;
2. Газрын хил зааг;
3. Геодезийн байр зүйн зураг;
4. Инженер-геологийн мэдээлэл (байгаа бол);

Хот байгуулалтын нөхцөл

1. Холбогдох ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө;
2. Өндрийн болон нягтралын хязгаарлалт;
3. Зам, хөдөлгөөний нөхцөл;
4. Инженерийн шугам сүлжээний мэдээлэл.

Соёлын өвийн хамгаалалтын нөхцөл - нэмэлт

1. Өвийн хамгаалалтын шаардлага;
2. Холбогдох хууль, дүрэм, стандартууд.

07 Суурь судалгааны материал


1. Сан хөмрөгийн хэсгийг олон улсын музейн стандартын дагуу температур, чийгшлийн хяналттай HVAC системтэй төлөвлөх.
2. Үзэсгэлэнгийн танхимууд нь хөдөлгөөнт хана (movable wall), музейн зориулалтын гэрэлтүүлэгтэй байх.
3. Үзмэр тээвэрлэлтийн зориулалттай тусдаа үйлчилгээний орц, ачаа буулгах хэсэг төлөвлөх.

Чойжин ламын сүм музей нь нийт 6,000 гаруй үзмэртэй бөгөөд үүнээс 4,000 орчим үзмэрийг зориулалтын сан хөмрөгт хадгалах шаардлагатай байна. Музейн хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулах, үзэсгэлэнгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, судалгаа шинжилгээ болон нөхөн сэргээх үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор төлөвлөж буй шинэ барилгад дараах үндсэн өрөө тасалгааг тусгах шаардлагатай гэж үзэж байна. (Захиалгчын боломжит хүсэлтийг харгалзан үзнэ үү.)

ӨРӨӨ ТАСАЛГААНЫ

1	Сан хөмрөг, тусгай хадгалалтын өрөө	30–35%
2	Үзэсгэлэнгийн танхим /байнгын болон түр/	25–30%
3	Үзмэр хүлээн авах, савлах, задлах, түр хадгалах хэсэг	7–10%
4	Нөхөн сэргээх лаборатори, судалгааны өрөө	6–8%
5	Захиргаа, ажилчдын оффис	8–10%
6	Лобби, тасалбар, мэдээллийн хэсэг	6–8%
7	Соёлын боловсрол, лекц, сургалтын өрөө	5–7%
8	Кофе шоп, бэлэг дурсгалын дэлгүүр	5–7%
9	Ариун цэврийн өрөө, хүртээмжийн дэд бүтэц	4–5%
10	Инженерийн өрөө, сервер, нөөц цахилгаан, хамгаалалтын хэсэг	5–7%
11	Коридор, шат, лифт, дотоод хөдөлгөөний талбай	10–15%

08 Суурь судалгааны материал



238

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр

Дугаар 96

Улаанбаатар хот

Хамгаалалтын бүс тогтоох тухай

Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:


1. Нийслэлийн нутаг дэвсгэрт оршдог түүх, соёлын үл хөдлөх дурсгалууд болох Гандантэгчинлэн хийд, Гэсэр сүмийн хамгаалалтын бүсийг 58,0 га, Богд хааны Ногоон ордны хамгаалалтын бүсийг 5,7 га, Чойжин ламын сүмийн хамгаалалтын бүсийг 2,0 га, Дамбадаржаа хийдийн хамгаалалтын бүсийг 10,5 га, Гэр хэлбэрт модон дугануудбуюу Дашчойлин хийдийн хамгаалалтын бүсийг 1,7 га, Чин ван Ханддоржийн байшингийн хамгаалалтын бүсийг 0,5 га газар байхаар тус тус тогтоосугай.

2. Хамгаалалтын бүсэд түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн хадгалалт хамгаалалт, бүрэн бүтэн байдалд хохирол учруулахуйц үйл ажиллагаа явуулах, барилга барихгүй байхыг Нийслэлийн Засаг дарга М.Энхболдод даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.ЭНХБАЯР

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.ЦАНЖИД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН АРХИВ
Огноо 2010.05.08 № 78
ХУУЛЬ ЗҮЙН ҮНЭН









Боловсруулсан: монголын Архитекторуудын Эвлэл

08 Суурь судалгааны материал



Уралдааны төслийн хил хязгаар







Боловсруулсан:

монголын Архитекторуудын Эвлэл

09 Суурь судалгааны материал



1988 онд хийгдсэн Түүх соёлын дурсгалт зүйлийг сэргээн засварлах газарт боловсруулж байжээ.



1. Махранзын сүм
2. Зүүн сүм
3. Баруун сүм
4. Дунд асар хаалга

Тайлбар бичиг

Чойжин ламын сүм музейн конторын барилгын зураг төслийг Музей удирдах газрын 1988 оны 3-р сарын 15-ны 67 тоот, Соёлын Яамны 1988 оны 6-р сарын 2-ны у/т 1045 тоот албан бичгүүдийг үндэслэн боловсруулав.

Чойжин ламын сүмийн дүрэмшсэн дүрслэл Хэнсүй барваны нэгдэл, Нэшгэрэлийн музейг ашиглах болонгүй, хэрэгээ дотор болон гадна өрөөн үеийн барилга барьж болохгүй ном. 1930-д оны архивын гэрэл зураг. Жүдэрийн зурсан, 1911 оны Нийслэл хүрээ" зэрэг зургас. үзэхэд Махранзаар дамжин сүрэд Дунд асар хаалга хүртлэх замын хөөр талд /хэрэмэн дотор/ тэгш хэмийн байгуулалтай хөөр ижил сүм барсан нь батлагдаж байна. Одоо уг 2 сүм байхгүй учраас архитектурын талаалалт, зохиомжийг эдэлж Махранз, Дунд асар хаалга хөөрөн дунд хоосон зай хэнхэрч байснаа Дунд асар хаалганы шөвөг нилээд шаазгайлсан байдалтай харагдаж байна. Иймээс уг чулуулгын архитектурын зохиомж, талаалалтыг харгалзан үзэж, уг 2 сүмийг тэрхүү хоосон зайд гадна талын анхных нь төрх байдлаар, дотор талыг эзэнлагчийн шаардлагын дагуу талаалан зураг төслийг зохиолоо. 2 сүмийн гадна талын зургийг зохиодоо ёсэвд сүмүүд болон Занхан сүлтэй харшуулан гэрэл зургийг үндэслэн хийц, хэмжээ, архитектурын дэлгэрэнгүйг хийсэн ёсэвд хоорондоо ялгаатай болгов.

Суурь: Уг 2 сүм нь бетонон суурьтай. Бетон марк 200. -0.45 төвшин хүртэл бетоноор суурь хийх, ±0.00 төвшин хүртэл М 100 маркийн улаан тоосгоор дотоолж, хөх тоосгоор өнгөлнө. Үүнд тэгшлэгчийг 1:3 шаврантэй зуурмагаар 2см зузаантай -0.45; 0.00 төвшинд хийж өгнө. ±0.00 төвшинд барзгин чулуугаар сүмийн тойрон эмжээр хийх бэ шатыг өөрийн чулуугаар хийнэ.

Шал: Сэрвэчны шал хөх тоосго, бусад өрөө тасалгаа нь модон шалтай.

Хана: 64 см-ийн тоосон ханатай. Зураг үзүүлсний дагуу зарим хөөн гадна талыг хөх тоосгоор өнгөлөх бэ зарилыг шаварлаж, цагаан шохойгоор будна.

Цонх: Бусад сүмийн адил дээжээр сэрвэлжин шонхтой, дотор талбесөө шиллэгэртэй. Сүмийн өр талд Ц 15-15 цонх хийх ёсэвд гадна талаас сэрвэлжин дан шонх хийж өгнө.


Хаалга: Сүмийн гадна хаалга, зөндөн өрөө, хөлийн өрөөний хаалга нь сэрвэлжин шонхтой хаалга байх ёсэвд бусад өрөө тасалгаанууд, хб21-7, хб21-8 маркийн хаалга байна.

Таз: Зөндөн өрөө, хөлийн өрөөний таз нь зүлгэртэй хэртэй хавтантай дүүжин тазтай, бусад өрөө тасалгаанууд жирийн тазтай байна. Сэрвэлжны хэсэг тазгүй.

Дээвэр: Хөх өөрөөн дорвэртэй, ёьл дэлгэнь шаазгайтай хавтантай, 2 лууттай. Хажуу дэл 4 лууттай, үзүүрийн 4 чимэглэлтэй байна.

Зургийн жагсаалт


д/д	Зургийн нэр	Кодлос
1.	Нүүр хуудас	
2.	Өмнөхийг тодорхойлох, тайлбар бичиг, зургийн жагсаалт	БА-1
3.	Байгууллалт	БА-2
4.	Суурийн байгууллалт	БА-3
5.	Нүүр тал	БА-4
6.	Хажуу тал, дэлгэний үзүүрийн чимэглэл	БА-5
7	Ар тал	БА-6
8	Хөндлөн огтлол, хэсэглэл	БА-7
9	Ёс модны задаргаа	БА-8
10	Дам нурууны байгууллалт, огтлол	БА-9
11	Дүүжит тазны байгууллалт	БА-10
12	Нүүр талын хаалга, хэсэглэл, модны түүвэр	БА-11
13.	Нүүр тал, ар талын цонхны зураг, хэсэглэл, түүвэр	БА-12
14	Дотор талын хаалга, өөрчүл	БА-13
15	Баганын далбаа, үүлэн хэв	БА-14
16.	Дээврийн байгууллалт	БА-15
17.	Дээврийн бөөрөн эдлэлүүд, түүвэр	БА-16
18	Дээврийн гол дэлний хүү	БА-17
19	Дээврийн хажуу дэлний хүү	БА-18
20.	Гол дэлний лүүны суурь, тоосго, мөнгний үзүүрийн өнгөлгөө	БА-19
21	Гол дэлний шаазгай хавтан, салхивчны тоосго	БА-20
22	Ханын шаазгай хавтан	БА-21



Боловсруулсан:


монголын Архитекторуудын Эвлэл


10 Суурь судалгааны материал



Боловсруулсан: монголын Архитекторуудын Эвлэл

11 Суурь судалгааны материал





ЧОЙЖИН ЛАМЫН СУМ МУЗЕЙ

МАЭ

Уралдааны удирдамжид
Танд хуваалцах санал хүсэлт, сэтгэгдэл
байвал, манай цахим хаягууд руу DM
бичээрэй.

Илүү ихийг @uma_mongolian

FOLLOW

2026 он

"ЧОЙЖИН ЛАМЫН СҮМ МУЗЕЙН"

САН ХӨМРӨГ, ЗАХИРГААНЫ БАРИЛГА АРХИТЕКТУРЫН ЗУРАГ ТӨСЛИЙН УРАЛДААНЫ

2026/03

ХОЁРДУГААР ШАТНЫ УДИРДАМЖ



2026 он

01 ХОЁРДУГААР ШАТНЫ ДААЛГАВАР, УДИРДАМЖ

Түүхэн орчин, архитектурын ансамблийн шийдэл

Шүүгчдийн зөвлөлийн нэгдсэн саналын дагуу оролцогчид төслөө боловсруулахдаа Чойжин ламын сүм музейн түүх, соёлын үнэ цэн, архитектурын өвийн онцлогийг хадгалан хамгаалах, тодотгон харуулах зарчмыг баримтална.

Төслийн зорилго нь зөвхөн сан хөмрөг, захиргааны барилга төлөвлөх бус, харин Чойжин ламын сүм музей болон түүний орчмын түүхэн орон зайг хамгаалсан, нэгдмэл архитектур, хот байгуулалтын ансамбль бүрдүүлэхэд чиглэнэ.

Иймд оролцогчид дараах асуудлуудыг 2-р шатанд зураг төсөлдөө тусган боловсруулна. Үүнд:

- Чойжин ламын сүм музейн архитектурын үнэ цэнэ, түүхэн дүр төрх, сүр барааг тодотгон харуулах зорилгоор Төрийн ордон – Сүхбаатарын талбай – Чойжин ламын сүм музей – Богд уул чиглэлийн харааны болон орон зайн холбоог хадгалж, түүхэн орчны дүр төрхийг хамгаалах төлөвлөлтийн санал боловсруулах;
- Ойр орчмын барилга байгууламжийн өндөр, эзлэхүүн, фасадын өнгө, материалд санал боловсруулах
- Чойжин ламын сүм музейн цогцолборын орчны ландшафт, ногоон байгууламж, задгай талбайн төлөвлөлтийг нэгдсэн байдлаар авч үзэх;

2. Авто зогсоол, хөдөлгөөний зохион байгуулалтын шийдэл

- Авто зогсоолын, автобусны зогсоол төлөвлөлтийг холбогдох БНбД болон бусад норм, дүрмийн шаардлагад нийцүүлэн боловсруулах;
- Жуулчин, зочдод зориулсан авто зогсоолыг тухайн талбай болон ойр орчмын боломжит байршлуудад дундын ашиглалтын хэлбэрээр шийдвэрлэх боломжит хувилбаруудыг судлан санал болгох.

3. Архитектурын зураг төслийн бүрдэл

- Архитектурын зураг төслийн уралдааны даалгаврын дагуу ерөнхий төлөвлөгөө, байгуулалт, фасад, дагуу болон хөндлөн огтлол, харагдах байдал, перспектив зураг зэрэг үндсэн бүрдлийг боловсруулах;

Чойжин Ламын Сүм музейн үйлчлүүлэгчдийн тоон мэдээлэл

Сар	2023	2024	2025	2026
1 сар	217	100	252	33
2 сар	251	121	106	193
3 сар	106	237	110	178
4 сар	414	425	257	274
5 сар	267	486	375	—
6 сар	879	759	802	—
7 сар	1,231	1,584	1,093	—
8 сар	1,203	1,154	1,515	—
9 сар	931	913	1,104	—
10 сар	277	383	291	—
11 сар	305	320	259	—
12 сар	67	135	147	—
Нийт	6,148	6,617	6,311	678

ХУГАЦААНЫ ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙ
Анх 2026 оны 08 дугаар сарын 07-ны өдөр хоёрдугаар шатанд шалгарсан оролцогчдод мэдээлэл хүргэхээр төлөвлөж байсан боловч шүүгчдийн бүрэлдэхүүнээс ирүүлсэн санал, зөвлөмжийг нэгтгэх, нэгдсэн дүгнэлт боловсруулах шаардлага үүссэнтэй холбоотойгоор уралдааны хоёрдугаар шатны хугацаанд дараах өөрчлөлтийг оруулж байна.

Хоёрдугаар шатны хугацаа
2026 оны 08 дугаар сарын 17-ны өдрөөс 2026 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр хүртэл

БҮТЭЭЛ ХҮЛЭЭН АВАХ ЖУРАМ

Хоёрдугаар шатанд оролцогчдоос дараах материалыг хүлээн авна.
Ирүүлэх материал
- 1100 x 1600 мм хэмжээтэй босоо форматтай самбарууд (4 хүртэлх);
- Тайлбар бичиг;
- Танилцуулгын файл (PDF болон Presentation файл).

Анхаарах зүйл
- Хоёрдугаар шатанд бүтээлийг USB флаш санах ойд урьдчилан ирүүлэх шаардлагагүй.
- Багууд өөрсдийн танилцуулгын файлыг хамгаалж хадгалан, танилцуулах өдөр авчирна.
- Танилцуулгын үеэр ашиглах файлуудыг **2026 оны 09 дүгээр сарын 20-ны** өдөр зохион байгуулагчид хүлээн авна.

ТӨСӨЛ ТАНИЛЦУУЛАХ ӨДӨР
2026 оны 09 дүгээр сарын 21-ны өдөр 09:00 цагаас МАЭ-ын байрны 3-р давхарт

Танилцуулга 15 минут, асуулт хариулт
- PDF болон презентацийн файлуудаа ирүүлэх;
- Багийн төлөөлөгч төслийг танилцуулах;
- Шүүгчдийн асуултад хариулах;

Жич: Олон улсын оролцогчид цахимаар танилцуулга хийж болно. Орчуулагчтай танилцуулга хийх бол урьдчилан зохион байгуулагчид заавал мэдэгдэнэ үү.

ҮЗЭСГЭЛЭН, ШАГНАЛ ГАРДУУЛАХ ЁСЛОЛ
2026 оны 09 дүгээр сарын 26

Уралдаанд ирүүлсэн бүтээлүүд болон нэгдүгээр болон хоёрдугаар шатанд шалгарсан төслүүдийн нээлттэй үзэсгэлэнг зохион байгуулна.
Үзэсгэлэнгийн хүрээнд:
- Уралдааны бүтээлүүдийг олон нийтэд дэлгэн үзүүлэх;
- Шүүгчдийг танилцуулах
- Шүүгчдийн дүгнэлтийг танилцуулах;
- Шалгарсан оролцогчдод шагнал гардуулах ёслол
- Мэргэжилтнүүдийн дунд зохион байгуулах нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах;

болно.

ЧОЙЖИН ЛАМЫН СУМ МУЗЕЙ

МАЭ

Уралдааны удирдамжид
Танд хуваалцах санал хүсэлт, сэтгэгдэл
байвал, манай цахим хаягууд руу DM
бичээрэй.

Илүү ихийг @uma_mongolian

FOLLOW

2026 он